

Өнгөрсөн 1986 оны 10—11-р сард Их Британий нэгдсэн вант улсад эрдэм шинжилгээний томилолтоор очиж, Лондон, Лидз, Кэмбридж, Оксфорд, Рединг, Айва хотуудаар орж, Монгол, Төв Ази, дорнодахины судлалын зарим төвүүдтэй нь биечлэн танилцаж, нэлээд эрдэмтэн мэргэжилтэн нартай уулзаж ярилцах аятай боломж гарсан юм. Энэ ажилд Британий зөвлөлийн зэрэг зарим байгууллага, хүмүүс бодитой тусламж дэмжлэг үзүүлсэн болохыг тэмдэглэн талархнам.

Британий Номын сан, Лондон, Лидз, Кэмбридж, Оксфордын их сургуулиудын номын санд Монголын түүх, соёлын сурвалж баримт нэлээд байхын дээр хамгийн гол нь англи, франц, герман, япон, хятад хэлээр бичигдсэн судалгааны хуучин, шинэ зохиол арвин байгаа нь анхаарал татах зүйлийн нэг болж байв. Тэр бүхэн нь Англид Монголын судлал үүсч хөгжих материаллаг бааз суурь болж өгсөн байна.

Дорнодахины судлал, Төв Азийн судалгаа Англид их л эрт үүсч хөгжжээ. Монголын судлал тэнд XIX зууны 70—80-аад оны үест Х. Ховорс гэдэг эрдэмтэн 5 боть «Монголчуудын түүх» (Лондон, 1876—1888, 1927) туурвих цагаас анх уусан хөгжжээ.

XX зууны тэргүүн хагас, дунд үед Англид Дж. Бадделей, Е. Филлипс, Дж. А. Бойл, Айвор Монтагш нарын зэрэг монголч нар ажиллаж байжээ.

Англи бол капиталист орон учир тэнд Монголын судлал анхнаасаа хөрөнгөтний Монголын судлалын чиглэлээр үүсч хөгжсөөр иржээ.

Английн Монгол судлалын цаашдын хөгжилд 1963 онд Англи-Монголын нийгэмлэг байгуулагдаж, Лидзийн их сургууль дээр нэрт дорнодахинч Оуэн Латтимор, Онон Өргөнгөө нарын үндэслэн байгуулсан Монгол судлалын төв бий болсон явдал чухал үүрэг гүйцэтгэжээ. Одоо Англи Монголын нийгэмлэгийн дарга нь Британий академийн гишүүн, нэрт эрдэмтэн Эдмунд Лийч, ерөнхий нарийн бичгийн дарга нь доктор Харолина Хамфрий, тэргүүлэгч гишүүд нь Аллен Сандерс, Онон Өргөнгөө нарын зэрэг монголч эрдэмтэд, бусад хүмүүс юм байна. 1986 оны тэргүүн хагаст доктор Х. Хамфрий, О. Өргөнгөө нарын зэрэг английн Монголчид Кэмбриджийн Их сургуулийн нийгмийн хүн судлалын факультет дээр Монгол, дотоод Азийн судлалын нэгж шинээр байгуулж, тус орны Монголын судлалын төвийг тийш нь шилжүүлсэн байна. Английн Монгол судлалын тэрхүү нэгжид одоо Х. Хамфрий, О. Өргөнгөө нараас гадна А. Никсон, К. Пег, К. Шабро, Дж. Гоонт нарын зэрэг эрдэмтэн, мэргэжилтэн нар ажиллаж, Монголын эрт, эдүгээгийн түүх, соёл, гадаад харилцааны зарим асуудлыг судлан боловсруулж байна. Кэмбриджид бас профессор С. Х. Бэйлийн толгойлсон эртний Энэтхэг, Ираны трест хэмээх Төв Азийн судлалын төв байдаг, тэр нь Английн Монгол судлалын нэгж, Англи-Монголын нийгэмлэгтэй нягт харилцаатай ажилладаг ажээ. Англи-Монголын нийгэмлэг, Английн Монгол судлалын нэгжээс эрхэлж Англи-Монголын нийгэмлэгийн сэтгүүл» жил бүр нийтэлж байна. Тус сэтгүүлийн зарим дугаарт монгол эрдэмтдийн бичсэн өгүүлэл сэлтийг орчуулж хэвлэсэн үзэгдэнэ.

Лондонгийн их сургуулийн дорно дахины ба Африкийн судлалын

сургууль дээр Британий академийн гишүүн, нэрт монголч эрдэмтэн Чарльз Боуден олон жилийн турш ажиллаж иржээ.

Лондонгийн их сургуулийн ууган факультетын нэг болох университетийн колледжийн Цааз хуулийн факультетийн декан, проф. В. Батлер БНМАУ-ын хуулийг судалж байна. Лондонгийн их сургууль дээр профессор Д. Морган, Ш. Акинер нарын зэрэг эрдэмтэд Дундад Ази, Иран, Түрэгийн судлалтай уялдуулж, Монголын түүх, соёлын зарим асуудал судалж байна.

Лидзийн Их сургуулийн Хятадын судлалын факультет дээр Дж. Нордбай нарын зэрэг монголч эрдэмтэд ажиллаж байна. Тус Их Сургуулийн гадаад хэлний ангид Монголоос очсон залуучууд англи хэлний дадлага хийж, мэргэжлээ дээшлүүлдэг ажээ.

Рединг хотод английн Монголч эрдэмтэн А. Сандерс ажиллаж, орчин үеийн БНМАУ-ын дотоод байдал, гадаад бодлогын талаар судалгаа хийж байна.

Оксфордын Их сургуульд Хятад, Төвд судлал хүчтэй хөгжсөн, Монгол судлалаар тусгайлан ажилладаггүй боловч Зөвлөлт ба Дорнод Европын эдийн засгийг судлагч М. Казер нарын зэрэг зарим эрдэмтэд Монгол, төв ба дундад Азийн судлалын зарим асуудлыг сонирхон судалж байна.

Лондонд Төв Азийн судалгааны төв, Оксфордод Төв Азийг судлах нийгэмлэг байгааг Д. Морисон хэмээх эрдэмтэн толгойлж, Монголын түүх, соёлын зарим зүйлийг судлах ажил хийж байна.

Англид Монголын судлалыг гол төлөв Умард Азийн судалгаанд хамааруулж, социалист орнуудын амьдрал, хөгжил, гадаад харилцааны асуудлыг судлах явдалтай уялдуулан явуулж байна.

Английн Монголын судлалын мэргэжилтэн тийм олон биш боловч тэд нарын эрдмийн бүтээл цөөнгүй, Монголын судлалд оруулж байгаа хувь нэмэр багагүй ажээ. Профессор Боуден «Алтан товч, орчуулга, тайлбар» (1955 он), «Монголын орчин үеийн түүх» (1968), «Бөө нар, лам нар ба евангелистүүд» (1985), К. Хамфрий «Карл Марксын нэрэмжит хамтрал» (1983), «Умард Азийн бөө мөргөлийн холбогдолт үзэл онолууд» (1976), «ЗСБНХУ-ын угсаатны зүйн ухааны сүүлчийн үеийн зарим хөгжилт» (1982, тойм өгүүлэл) зэрэг зүйл бичиж нийтлүүлжээ. О. Өргөнгөө «БНМАУ-ын түүх-ийн 3-р ботийг англичилж, эрдэм шинжилгээний оршил, тайлбартай нийтлүүлэлцсэн (1976), «XX зууны Монгол баатрууд» (1976), «БНМАУ» (1980, 81) гэх зэрэг зохиол, өгүүлэл бичсэн байна. А. Сандрес «БНМАУ, ерөнхий лавламж» (1968) хэмээх зохиол, олон өгүүлэл, В. Батлер «Монголын хуулийн тогтолцоо» (1982) гэх зэрэг ном өгүүлэл бичжээ. Д. Морган 1986 онд «Монголчууд» гэдэг зохиол шинээр бичиж нийтлүүлсэн байна.

Английн эрдэмтдийн бичсэн Монголын судлалын зохиолуудад БНМАУ-ын түүх, соёл, гадаад харилцааны асуудлыг тайлбарлаж дүгнэхдээ үнэн байдалд тэр бүрий нийцүүлээгүй, бидний үзэлд харш зарим зүйл байвч дийлэнх ихэнх нь бодит баримт дээр тулгуурлан туурвисан эрдэм шинжилгээний үнэ цэнэ бүхий зүйл гэж үзэхэд болох талтай байна. Тэдний нэлээд нь Монгол эрдэмтдийн бүтээлд орсон баримт, тэдний дэвшүүлсэн санаа дүгнэлтийг их, бага аливаа хэмжээгээр ойшоон анхаарч, тус тусын бүтээлд боломжийн хирээр тусган тайлбарлахыг оролдсон байна. Тийм учир тэдний зүгээс Монголын эрдэм шинжилгээний байгууллага, номын сангуудтай ном солилцох, эрдэмтдийн хооронд харилцаа холбоо тогтоох хүсэлт эрмэлзлэл багагүй гарах болж байна.

Британий академийн дэд ерөнхийлөгч Петер Браун, Британий Зөвлөлийн хэлтсийн эрхлэгч Джереми Барнетт, тус зөвлөлийн хариуцлагатай ажилтан Бен Кофий нарын зэрэг уулзаж учирсан удирдлагын хүмүүс цөм Англид Монголын судлалыг хөгжүүлэх, англи, Монголын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн харилцаа холбоог өргөтгөх явдлыг чухалчлан дэмжих тухай найрсаг дотно ярилцаж байв.

**НЭГЭН НЭРТ ОТОЧ-ЭМЧ,  
ТҮҮНИЙ БҮТЭЭЛИЙН  
ТУХАЙД**

Н. ДАШЗЭВЭГ

Монголын эртний анагаах ухааны түүхийг судлахад юуны түрүүнд Монгол оронд дэлгэрч байсан бөө мөргөлийн ба шарын шашин болон түүний ихэс лам нарын түүхэн намтар, мөн нэн эртний түүх, археологийн баримт сэлт, угсаатны зүй, үлгэр туульс, ардын аман зохиол зэрэг судлалд тулгуурлан судлаж байдаг байна. Түүний дотор Монголд эртний Энэтхэг, Төвдийн эмнэлэг засал, эм зүйн сургуулийг анх үндэслэн дэлгэрүүлэгчдийн нэг болох ламын гэгээн Лувсанданзанжанцан, Халхын Зая Бандида Лувсанпэрэнлэй, баруун монголын Зая бандида Намхайжанцан нарын үйл ажиллагаа, намтар түүх ихээхэн холбоотой байдаг.

Ялангуяа энэ талаар ламын гэгээн Эрдэнэ бандида Лувсанданзанжанцан бол Монголын анхны ууган оточ-эмчийн нэг болохыг манай улсын түүхэнд дэлгэрэнгүй бичсэн. Лувсанданзанжанцан 11-р жараны шороон туулай жил буюу 1639 оны хаврын эхэн сарын 15-нд Түшээт хааны удмын засаг эрх Чойхүр гэдэг ноёны гэрт Өлзийт Овоо (Одоогийн Өвөрхангай аймгийн Хангай хааны орчим) гэдэг газар төржээ. Тэрээр эцгийн тусламжтайгаар 5 наснаас эхлэн Дашлхүнбо хийдийн Цорж Лувсаняринпилээр 17 нас хүртэл төвд ном заалгаж Өндөр гэгээний багш Бэрэбун хийдийн цорж нялба Намхайсодномдагваас зөвлөлгөө авч байжээ.

Лувсанданзанжанцан 18 настайдаа 1655 онд Төвдийн Лхас (Баруун зуун)-д очиж далай лам, Ванчин-Богд нартай уулзаж, улмаар Гүнбум хийдийн цорж Пэрэнлэйжамц зэрэг 60 гаруй багшаар эртний Энэтхэг Төвдийн их бага арван ухааны номуудыг заалгаж Лхас ба Дашлхүнбод 22 жил суужээ. Тэгээд энэ завсраа анх Төвдөд явахад нь Өндөр Гэгээн тусгайлан захисан ёсоор Анагаах ухаан ба одон орон зурхайн номыг онц сайн сурахыг даалгасан учир анх<sup>1</sup> төвд газрын оточ Гунгаажанчив мөн Лувсандамбадаржаа нараар анагаах ухааны цогт дөрвөн үндэсний ном, мөн түүний хөтөлбөр, судрууд, бас анагаах ухааны олон төрлийн арга заслалын элдэв нэрийн номууд, мэс заслын багаж хэрэгслэлийг эзэмших гарын авлага зэрэг олон номыг заалгаж мэргэжсэн учир Баруун зууд маарамбын дамжаа барьж цол хамгаалж эмчийн хамгийн дээд лхаржи цол хүртжээ. Бас Төвд даяар эмийн хаан 2-р бурхан хэмээгдэх 5-р далай лам Агваанлуvsсанжамцад шавь орж анагаах ухааны бүх номын чухал нууц нэр увьдас, аргыг авч эмийн цогт дөрвөн үндэсний хөтөлбөр, эмийн зүрхэн хураангуй, гэх зэрэг маш олон номуудыг заалгаж, бүрэн сурчээ. Мөн Лувсанданзанжанцан нь төвдөд байх хугацаандаа эмийн номуудыг сайн суралцахын хамт хурал номын аялгуу хөгжим, бурхны бие ба түү-

1. М. Лүнрэгдандар. Монголын эмнэлгийн түүхийн ном, 120 хуудас, Төвд хэлээр